

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

10-Р САРЫН 16, 2020

Эдийн засгийн судалгааны алба

Аравдугаар сарын 21-23-ны өдрүүдэд Монгол Улс FATF-ийн саарал жагсаалтаас гарах эсэхийг албан ёсоор зарлах болно. Сангийн яаманд болсон эхний шатны онлайн хурал амжилттай зохион байгуулагдаж, 100 гаруй төлөөлөгчид Монгол Улсыг саарал жагсаалтаас хасахаар баталлаа. Эцсийн шатны хуралд жагсаалтаас хасагдах нь манай улсад тавигдаж буй гадаад, дотоод гүйлгээний хяналтыг бууруулах юм.

Импортын тээврийн барааны бүлэг нь үнийн түвшин буурахад 47 хувийн нөлөөтэй байна. 2020 оны 9-р сарын байдлаар инфляцийн улсын индекс 1.7 хувь, Улаанбаатарт 1.4 хувьд хүрсэн нь 2016 оноос хойших хамгийн доод түвшин юм.. Үнийн уналт, тоо хэмжээний уналт 7-р сараас хойш сэргэж байна.


Данс хоорондын шилжилттэй холбоотойгоор гадаад валютын хадгаламж мэдэгдэхүйц өсжээ. Банкны систем дэх гадаад валютын хадгаламжийн нийт хэмжээ сүүлийн 4 сарын хугацаанд мэдэгдэхүйц өсч байна. 76 хувийн өсөлт нь гадаад валютын орох урсгалаас гадна өөрийн данс хоорондын шилжилт, гол төлөв харилцах болон хугацаагүй хадгаламжаас хугацаатай хадгаламж руу шилжснээс үүджээ. Харин төгрөгийн хадгаламж жилийн дүнгээр 7 хувиар өссөн байна. Үүний үр дүнд мөнгөний нийлүүлэлт жилийн 9 хувиар өссөн байна.

Нүүрс, алтны экспортын өсөлтөөр нийт экспорт сэргэж байна. Харин хэрэглэгчдийн эрэлт суларснаас импортын бүтээгдэхүүн өмнөх жилийнхтэй харьцуулахад буурчээ. Үүнээс автомашины импорт 36 хувиар, шатахууны импорт 26 хувиар буурав (шатахууны үнэ буурсантай холбоотойгоор). Ингэснээр гадаад худалдааны тэнцэл 1.2 тэрбум ам.долларын ашигтай гарсан ч, өмнөх оноос найман хувиар буурчээ.

Засгийн газрын 2020 оны төсөвт дотоод, гадаадын зээлтэйгээ нийт 5.8 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдана. Коронавирусаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний улмаас засгийн газрын орлого хараахан сэргэж чадахгүй байна. Орлогын гол уналт нь нийгмийн даатгалын орлогоос гадна орлогын албан татвар буурсантай холбоотой. Татварын орлого нь нийт орлогын 84 хувийг эзэлж байна. Зарлага талаас нийгмийн халамжийн урсгал шилжүүлэг нь засгийн газрын нийт зардлын 37 хувийг эзэлж байна.


ЭЗ Агент	Үзүүлэлт	Нэгж	2019.Q2	2019.Q4	2020.Q2	YoY /2020/
Бодит сектор	Бодит ДНБ өсөлт	%	7.2%	5.1%	-9.7%	-18.9 p.p
	Уул уурхайн ДНБ	%	13.3%	0.4%	-29.4%	-42.7 p.p
	Ажилгүйдлийн түвшин	%	10.1%	8.1%	6.6%	-4 p.p
	Ажилтай иргэд	Мянган хүн	1,293	1,188	1,269	-2.0%
			2019.08	2019.12	2020.08	YoY /2020/
	Инфляци	%	9.0%	5.2%	1.7%	-7.3 p.p
Мөнгөний бодлого	M2, үүнээс:	Их наяд ₮	20.4	20.8	22.3	9%
	Вал.хадгаламж	Их наяд ₮	2.9	3.5	5.1	76%
	Төг.хадгаламж	Их наяд ₮	10.8	11.1	11.6	7%
	Бодлогын хүү	%	11%	11%	8%	-3 p.p
	(MNT/USD)	₮	2,667	2,727	2,855	7%
Сангийн бодлого	Төсвийн орлого	Их наяд ₮	7.8	10.8	6.7	-14%
	Төсвийн зардал	Их наяд ₮	7.3	11.5	9.4	29%
	Төсвийн тэнцэл	Их наяд ₮	0.48	-0.6	-2.7	
	Экспорт	Тэр ₮	5.9	7.1	5.1	-14%
Гадаад сектор	Импорт	Тэр ₮	4.6	6.1	3.9	-15%
	Гадаад худалд. тэнцэл	Тэр ₮	1.3	1.4	1.2	-8%
	Төлб.тэнцэл /2020.08/	Сая \$	39	453	-399	
	ГШХО /2020.08/	Сая \$	1,359	2,316	1,050	-23%
	ГВАН /2020.08/	Сая \$	3,689	4,349	3,652	-1%

Эдийн засгийн өсөлт




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Улсын төсвийн тэнцэл




Эх сурвалж: Үндэсний статистик хороо


Мөнгөний нийлүүлэлт



Инфляци




Төлбөрийн тэнцэл




Гадаадын шууд хөрөнгө оруулалт


- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Хуримтлуулсан, Сая ам.доллар/
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Тухайн сарын, Сая ам.доллар/



Ам.долларын ханш



Хүү



Эдийн засгийн судалгааны алба:

Шинжээч
Г.Батзориг
Имэйл: Batzorig_g@golomtbank.com

Шинжээч
Э.Батхорлоо
Имэйл: Batkhorloo@golomtbank.com

Эх сурвалж
1212.mn
mongolbank.mn
Голомт банкны дотоод эх сурвалж

Голомт банкны эдийн засгийн судалгааны алба нь макро эдийн засгийн судалгаа болон таамаглалуудыг дотоод ажилчид, харилцагчид болон олон нийтэд хүргэн ажилладаг. Тус тайланд 2020 оны 8, 9-р сарын тоон мэдээлэл болон зарим тохиолдолд 2-р улирлын тоон мэдээллийг ашигласан болно. Энэхүү судалгаа нь зөвхөн банкны дотоод хэрэгцээнд зориулсан бөгөөд Голомт банкны үзэл баримтлалыг илэрхийлээгүй болно.

Улаанбаатар хот
2020 оны 10-р сар